

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

<p style="text-align: center;"><b>Цай</b></p>	<p>Зориулалт: Бизнес болон энгийн ангиллын зорчигчийн үйлчилгээнд</p> <p><b>Бизнес ангиллын цай:</b> 2 гр хэмжээтэй торон уутанд навчаараа савлагдсан тансаг зэрэглэлийн хандалдаг цай байх ба гадуураа чийг нэвтэрдэггүй тугалган/гялгар дугтуй хэлбэрийн ууттай байна.</p> <p><b>Энгийн ангиллын цай:</b> 2 гр хэмжээтэй цаасан филтерт савлагдсан байх ба гадуураа чийг нэврүүлдэггүй тугалган дугтуйтай байна.</p> <p><b>Шинж чанар:</b> Хандалдаг цай нь физик, химийн болоод эрүүл ахуйн аюулгүй байдлын үзүүлэлтүүдийн шаардлагыг хангасан, будаг, өнгө оруулагчгүй, жишиг авиа компаниудын үйлчилгээнд хэрэглэгддэг Twinings, TWG, English breakfast, Green tea зэрэг дэлхийд танигдсан бренд бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц байна.</p> <p><b>Савлагаа:</b> Бүтээгдэхүүний савлагаан дээр шошгололт олон улсын стандарт шаардлагыг хангасан байх ба үйлдвэрлэгдсэн болон хадгалалтын хугацаа тодорхой, байна. Нийлүүлснээс хойш 2 жилээс багагүй хугацаанд хүчинтэй байна</p> <p>25 ширхгээр багцалж ууталсан эсхүл хайрцагтай байна.</p> <p><b>Холбогдох сертификат:</b></p> <ol style="list-style-type: none"><li>1. Бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ</li><li>2. Тохирлын гэрчилгээ эсхүл эрүүл ахуйн болоод холбогдох бусад шаардлагуудыг хангасныг нотлох Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ.</li></ol> <ul style="list-style-type: none"><li>❖ Сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй байх.</li><li>❖ Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу загвар дээж ирүүлнэ.</li></ul>
---	---